



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 173

Ховд

Г Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1, 48 дугаар зүйлийн 48.1.1 дэх заалт, Засгийн Газрын 2019 оны ХЭГ/546 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын дүгнэлтээр сангийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, төсөл сонгон шалгаруулалт болон эргэн төлөлтөнд хяналт тавих чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Алтай, Булган, Баянт, Дарви, Дөргөн, Нуут, Зэрэг, Манхан, Мөнххайрхан, Ховд, Цэцэг, Чандмань, Эрдэнэбүрэн, Жаргалант сумдын Засаг дарга Б.Энхбаяр, Б.Амгаланбадрах, М.Пүрэвхүү, О.Ганцоож, Т.Заяа, А.Энхбаяр, Д.Октябрь, П.Мөнхбат, Б.Батболд, Ш.Ерболат, Ж.Мөнхзориг, Б.Галбадрах, У.Цэрэнтогтох, Ц.Ганданповрон нарт тус тус сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Сумын Орон нутгийн хөгжлийн сан болон сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хийсэн аудитын дүгнэлтээр буцаан төвлөрүүлэхээр тавигдсан акт болон зөрчил арилгахаар бичигдсэн албан шаардлагын биелэлтийг хариуцан хангаж дүнг 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн дотор танилцуулахыг дээрх сумдын болон Үенч, Мянгад сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Тус захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



02 D/Зак-АЛ173-Да